



### Living the Lotus Vol. 215 (2023.08)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami  
-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## Сэтгэл тайван амьдрахын тулд

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Бүх улс гүрнүүд аюулгүй байх арга замыг эрэлхийлэх нь

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага “эрүүл” гэдэг ойлголтыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. “Өвчингүй эсвэл сульдаж ядраагүй байдлыг хэлэхгүй, харин бие махбодийн хувьд ч сэтгэлзүйн хувьд ч нийгмийн харилцааны хувьд ч бүх талаараа хангагдсан нөхцөл байдлыг хэлнэ” гэж. Аз жаргалын тухай тодорхойлолт ч дээрхтэй утга ижил байдаг.

Гэвч ОХУ-ын Украин улс луу хийсэн дайралт, Сир, Судан, Мьянмар улсуудад гарч байгаа дотоодын зөрчилдөөн, олон улсуудад тулгараад байгаа дүрвэгч нарын асуудал, хүний эрхийн асуудлууд, мөн Япон улсын хувьд эргэн тойрны улсуудтай үүсээд байгаа асуудлууд гэх зэргээс улбаалан дэлхийн өнөөгийн нөхцөл байдлыг харахад жинхэнэ утгаараа эрүүл саруул, аз жаргалтай амьдарч байгаа хүн дэлхий дээр байхгүй гэж хэлэхэд хилсдэхгүй. Дэлхийн улс төрийн өнөөгийн байдал цэрэг, зэвсгийн хүчинд захирагдаж байна. Улс гүрнүүд зэвсэгт хүчнээ хүчитгэх тактикаар бие биендээ хаалт хийж, зэвсэгт мөргөлдөөн гарахаас сэргийлж байгаа нөхцөл байдалтай байна. Иймд өнгөц харахад энх тайван байгаа бүс нутаг, улс гүрнүүд аюулгүй мэт харагдавч үргэлж цэрэг зэвсгийн аюул заналаас эмээж байгаа дүр зураг харагдана.

Гэхдээ энэ бүхэн саяхан үүссэн зүйл биш юм. Үүсгэн байгуулагч аль 1982 онд “өнөөгийн дэлхий ертөнц хэзээ мөдгүй дэлхийн гуравдугаар дайн гарч магадгүй гэсэн хурцадмал нөхцөл байдалтай байна” гэж аюулын харанга дэлдэж байсан удаатай. Мөн “бүх зэр зэвсэг айдсаас үүдэлтэй бий болсон зүйл юм. Бусад улс орнууд довтлон дайрч магадгүй гэсэн эргэлзээ, айдас нь зэвсэгт хүчнийг илүү хүчирхжүүлэх үндэс болдог” гэж хэлээд тухайн үед явагдаж байсан цөмийн зэвсгийг зогсоох, зэвсэгт хүчний хүрээг хумих зорилготой гарын үсэг цуглуулах хөдөлгөөний ач холбогдлыг таниулахаар дуугарч байсан.

Гэвч өөрийн улс луу гадны улсууд дайрч, мөхөөж орхивол яана гэж бодох төдийд сэтгэл санаа тайвгүйрнэ. Дээрээс нь өөрийн улсыг хамгаална гэдэг нь өөрийнхөө амийг, цаашлаад гэр бүлээ хамгаалах гэсэн сэтгэлийн илэрхийлэл байдаг тул өөрсдийгөө хамгаалах зэвсгийг хүсэх нь хүний төрөлхийн чанар ч гэж хэлж болно. Гэсэн хэдий ч гадны улсын дайралтаас айж, дайсагнах, хаалт

хийх сэтгэл нь огтхон ч эрүүл арга биш юм. Энэ утгаараа бид бүхэн эрүүл саруул амьдрахын тулд зэвсэгт хүчнээ зузаатгахаас өөр аргаар өөрийнхөө улс орныг хамгаалах шаардлагатай бөгөөд өөрөөр хэлбэл бүх улс орнууд аюулгүй байх арга замыг эрэлхийлж, түүнийгээ бодитоор хэрэгжүүлэхийн төлөө явах хэрэгтэй.

## Өөрийгөө хайрлах лугаа

“Найман сар ба зургааны өдөр, есний өдөр, арван тавны өдөр” гэсэн мөрт байдаг. Энэ шүлэг нь Японы Нагасаки, Хирошима хотод атомын бөмбөг хаясан өдрийг илэрхийлж байгаа. Хүнлэг бус атомын зэвсгийн хар мөр, Японы дайнд ялагдсан тухай дурдах энэхүү шүлэгт дайны эсрэг харуусал, гашуудал, дайнд үрэгдсэн олон хүний сүнсийг амирлуулах бодол нэвт шингэсэн ба дайн дууссанаас хойш 78 жил өнгөрсөн боловч өнөөдөр ч сэтгэлд хүчтэй мэдрэмж төрүүлсэн хэвэндээ байна. Тийм л учраас дэлхийд амьдрах бүх хүн жинхэнэ утгаараа амар амгалан амьдрах боломжтой ертөнцийг бий болоосой гэж сэтгэлийн гүнээсээ хүсэхгүй байхын аргагүй.

Үүсгэн байгуулагч “дайн, мөргөлдөөн нь ашиг хонжоо хайсан сэтгэлээс үүсдэг. Үзэн ядалт, атаа жөтөөнөөс үүсдэг. Ийм нүгэлт сэтгэлээ дарах эсвэл багасгахыг хичээхгүй л бол хүний ертөнцөөс дайн тулаан гэдэг зүйл хэзээ ч арилахгүй” хэмээн дурдаад, “шашин шүтлэгээр дамжуулж хүн төрөлхтөний сэтгэлийг ариусгах явдал нь энх тайвны төлөөх дөт зам мөн” гэж тодорхой хэлсэн байдаг. Бурханы шашинд нигүүлсэнгүй сэтгэл, Христийн шашинд хайрыг хамгийн чухалчилдаг бөгөөд бусад шашнуудад ч төстэй сургаал байх учиртай.

Энх тайвантай холбогдох иймэрхүү сургаалд тулгуурлан хүн өөрт заяасан давтагдашгүй амь насаа хайрлан, өөрийгөө хайрлах лугаа бусдыг ч хайрлаж, хүндлэх хэрэгтэй. Ийм л ертөнцийг бүтээх нь шашин шүтлэгтэй хүний үүрэг гэж бодно. Үүнийг бодит ажил хэрэг болгохын тулд хамтарсан хүмүүсийн нэгдлээс Дэлхийн Шашинтнуудын Энх Тайвны Чуулган үүссэн түүхтэй.

Бидэн шиг энгийн хүмүүс дайныг зогсооно гэдэг бодит байдал дээр амаргүй даваа. Гэхдээ сүсэг бишрэлээр дамжуулан сэтгэлээ хөгжүүлэх нь нийгэм, улс орныг илүү сайн чиглэл лүү урагшлуулахад тус нэмэр болж чадна. Нигүүлсэнгүй сэтгэлээр өөрийгөө болон бусдыг харах, тэр сэтгэлийг түгээн дэлгэрүүлснээр нийгэм, улс орон хүртэл бүгдээрээ надтай нэгэн цул чухал оршихуун гэдгийг хүмүүст дамжуулах явдал чухал юм. Шашин шүтлэгтэй, шүтлэггүй байхаас үл хамаарч өөрийн улс орноор зогсохгүй, бусад улс орны хүмүүсийг ч хайрлаж, энэрэх анд нөхдүүд олон болсноор хүн бүхэн амар тайван амьдрах боломжтой дэлхийг бий болгох нөхцөл бүрдэнэ

<Косей> 2023 оны 8 сарын дугаараас



# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)


## Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

### Таван цээр – Таван сахил

Шагжамүни бурхан буддын шашинтны сайн дураараа баримтлах ёстой амьдралын зан үйлийн талаар бидэнд сургасан. Тэдгээрийн дотроос хамгийн чухал нь таван сахил (амьтны амь үл таслах, хулгай үл хийх, садар самууныг тэвчих, худал үл хэлэх, сархадыг үл хэрэглэх) юм.

Амьтны амь үл хөнөөх гэдэг нь учир шалтгаангүйгээр амьтны амь таслахгүй гэсэн үг бөгөөд мөн үнэт байгалийн баялгаа дэмий үрэхгүй байх явдал ч орно. Хулгай үл хийх гэдэг нь хулгай хийж болохгүй гэсэн үг. Буруу хурьцлыг эс үйлдэх гэдэг нь эсрэг хүйстэнтэйгээ цэвэр ариун харилцаатай байхыг хэлнэ.

Худал үл хэлэх гэдэг нь худал үг, дэмий яриаг ярихгүй байх явдал. Архи, сархадыг хэрэглэхгүй байх гэдэг нь архи хэтрүүлэн хэрэглэхгүй байх, хэт их уух, идэхээс болгоомжлох явдал юм.



#### Бяцхан мэдлэг

"Сахил" гэдэг нь хорио цээр болон хууль гэсэн хоёр үгээс бүрдсэн буддын шашны үг юм. Япон хэлнээ "сахил"-ыг "кайрицү" гэж нэрлэдэг. "Кай" гэдэг нь "Бурхны шашинтнуудын сайн дураараа дагаж мөрдөхийг тангарагласан дүрэм", "рицү" гэдэг нь "шашны хүрээнд тогтсон, заавал мөрдөх ёстой дүрэм" гэсэн утгатай.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Бүгд бурханы хүүхэд – Цагаан лянхуа судрын сургаал



Буддын шашны сургаалууд нь "наян дөрвөн мянга" байдаг гэж яригдах хэмжээний их бөгөөд эдгээрийг тэмдэглэсэн судар хэдэн мянгад хүрдэг.

Тэдгээрийн дотроос Цагаан лянхуа судрыг (дэлгэрэнгүйгээр Мёо хоо рэнгэ кёо гэнэ) хамгийн шилдэг судар хэмээн шүтэж, "бүх судрын хаан" гэж нэрлэж ирсэн.

Үүний нэг шалтгаан нь Цагаан лянхуа сударт "Энэ ертөнцийн хүн бүр Бурханы хүүхэд бөгөөд гарцаагүй Будда болж чадна" гэж номлосон байдаг.

Эрт үеэс Буддын шашинд нийгмийн байдлаа орхин лам болж, хатуу даяанд хамрагдсан лам нар л зөвхөн Будда болдог гэж үздэг байв. Гагцхүү Цагаан лянхуа судар л лам ч бай, энгийн буддын шашинтан ч бай хэн ч Будда болж чадна гэж сургажээ. Жишээлбэл, тусламж хэрэгтэй байгаа хэн нэгнийг хараад түүнд туслахыг хүсч, сайн үйл хийх өөдрөг

хүсэл таньд төрж байсан уу? Эсрэгээрээ, эцэг эх, найз нөхдөдөө худал хэлсний дараа сэтгэл санаа тавгүй болдоггүй гэж үү?

Энэ бол хүн бүр "Бурханы хүүхэд" гэдгийн баталгаа юм. Мөн энэ нь Будда шиг байхыг хүсч байгаагийн илрэл болно.

### Бяцхан мэдлэг

"Цагаан лянхуа судар"-ын "Үлгэрлэл гуравдугаар бүлэг"-т "Эх болсон зургаан зүйл хамаг амьтан миний үр хүүхэд" гэж Шагжамүни бурхан айлдсан байдаг. Энэ нь "энэ ертөнцийн бүх хүмүүс миний хүүхдүүд учраас би сургаалыг ялгаварлан гадуурхахгүйгээр адил тэгш дэлгэрүүлэх болно" гэсэн утгатай.

# Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК, удаах ерөнхийлөгч  
Нивано Коошоо

## Мартсан зүйл

Том охин маань тавдугаар ангид байхад болсон явдлын талаар ярья. Ням гарагийн оройн 7 цагийн үед “яадаг билээ! маргааш сургууль дээр үүнийг авч очих ёстой” гэсээр гэр ахуйн хичээлийн нэг хуудас бариад ирэв. Хуудсыг харвал хэд хэдэн өнгийн эсгийний өөдөс, нэхмэлийн утаснаас тэд дугаартайг, бөөрөнхий чимэглэл гэх мэтээр авчрах зүйлсийг жагсаан бичсэн байлаа. Миний нэхмэлийн хайрцагийг ухсан ч дутуу зүйлс байлаа.

“Яагаад эрт хэлээгүй юм бэ” гэж хэлж үзсэн ч, цаг хугацаа тулсан ийм үед үглээд нэмэргүй байлаа. Тэгээд том охиныгоо жаахан орхигдуулаад байдаг тул ширүүлэхээ больж, “за за хоёулаа дэлгүүр яваад ирье. Дэлгүүр хаасан ч байж магадгүй, ямарч байсан очоод үзье” гээд хамтдаа гар урлалын дэлгүүр лүү явлаа.

Азаар гар урлалын дэлгүүр онгорхой байж таарлаа. Хэрэгтэй зүйлсээ аваад, буцаж замдаа “дараагийн удаа иймэрхүү зүйлсийг эрт хэлж байгаарай” гэхэд, том охин маань тайвширсан царайтай, тортой зүйлсээ тас атгасан чигтээ толгой дохив.

Маргааш өглөө нь том, дунд охидуудаа сургууль руу нь үдэж гаргаад, удаа ч гүй байтал утас дуугарав. Том охин маань залгасан байлаа. “Өчигдөр авсан тортой зүйлээ үүдний өрөөнд орхиод ирчихжээ. Одоо галт тэрэгний буудал дээр байна, явал дээр вэ?” гэх нь тэр. Мартсан зүйлийг нь хүргэж өгч байсан удаа надад байхгүй тул, охин маань ч нэг их найдсан шинжгүй байлаа.

“Наанаа хүлээж байгаарай. Одоохон аваад очье”

Тэр өдөр би азаар завтай байж таарсан тул тортой зүйлийг нь аваад машинд суун галт тэрэгний буудал руу хурдаллаа. Замдаа “өчигдөр тэгж сайн хэлж байхад, дахиад мартаад байхдаа яахав дээ. Сайн хэлж сургахгүй бол болохгүйнээ!” гэж эх хүний “сургамжлах сэтгэл” буцалж эхлэв.

Гэвч дараагийн хоромд өөр бодол орж ирэв. “Охин маань албаар мартсан биш дээ. Авсан зүйлээ үүдний өрөө хүртэл авчраад, гарахаар бэлдэж байхдаа тэрүүхэн хооронд мартчихаж. Өчигдөр ажил болгон авсан зүйлээ мартаад, хэн хүнээс илүү охинд маань л хэцүү байгаа. Тэртээ тэргүй шаналж байхад нь би бас нэрмэс болоод юугхэв.” гэж бодов.

Галт тэрэгний буудалд хүрч ирэхэд охин маань дүү охинтойгоо хамтдаа хүлээгээд зогсож байлаа.

Намайг чиглэн гүйж ирсэн том охиндоо цонхоо онгойлгон “ашгүй амжлаа, зүгээр дээ цаг байгаа болохоор амжина, сандралгүй тайван яваад ирээрэй. Өнөөдөр ч гэсэн цагийг зугаатай өнгөрүүлээрэй” гэж хэлээд тортой зүйлийг нь өгөхөд царай нь гэрэлтээд явчихлаа. Тэгснээ “Ойлголоо, явчихаад ирье!” гээд цовоо сэргэлэн сургууль руугаа явав.

Охиныгоо араас нь хараад хамгийн баяртай байсан хүн би өөрөө байлаа. “Явах гэж байхад нь онцгүй зүйл хэлээд охиныхоо бүтэн өдрийг баллаад хаячихаагүй



## Нивано Коошоо

Рисшо Косей Кай байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуульч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараа тус байгууллагын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Судрыг судлан суралцахын хажуугаар гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтрах тал дээр анхааран ажиллаж байна. Мөн тус байгууллагын удаах ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

өөртөө баярлаж байсан болохоор. Ингэж баярлаж байгааг нь харахад сэтгэлд үнэхээр таатай байлаа”.

Жижигхэн зүйл байлаа ч түүний дотор орших эрдэнэсийг олж харж чадвал бид аз жаргалтай болдог гэж би боддог. Мэдээж дандаа тэгж чадна гэж байхгүй. Гэхдээ Үүсгэн байгуулагчаас аз жаргалтай болох нууцыг сурсан бид өдөр бүр их бага хэмжээгээр аз жаргалыг олж харж, аз жаргалыг мэдэрч амьдрахсан гэж бодно.

## Олон улсын хэлтсийн даргын булан



“Бие, хэл, сэтгэл”-ээрээ энх тайвны  
үйлсэд хувь нэмрээ оруулья

Акагава Кэйичи

Зуны ид халуун үе болох 8-р сар эхэллээ. Атомын бөмбөгдөлтөд өртсөн Япон улсад жил бүрийн наймдугаар сард бурхан болоочдын сүнсийг тайтгаруулах ёслол, энх тайвны төлөөх залбирлын арга хэмжээ зохиогддог.

Дайнаас хойш 78 жил өнгөрсөн ч дайны харуусал, шаналал, амь үрэгдэгсдийн төлөөх гашуудал өнөөдөр ч, ирээдүйд ч үүрд мөнхөд дурсагдсаар байх болно гэж би боддог.

Тухайлбал, энэ жилийн 5-р сард [Их долоогийн дээд хэмжээний уулзалт-Хирошима] Япон улсад болж, Их долоогийн төрийн тэргүүнүүдээс авахуулаад, уригдан ирсэн улс орнуудын удирдагчид, олон улсын байгууллагын тэргүүнүүдийн бүлэг, цаашилбал зочин оролцогч Украины Ерөнхийлөгч Зеленский нар бүгд тус тус Хирошимагийн энх тайвны дурсгалын цэцэрлэгт хүрээлэн дэх атомын бөмбөгөнд амь үрэгдэгсдэд зориулсан хөшөөний өмнө толгой бөхийж, бас энх тайвны дурсгалын музейд зочилсон билээ. Энэхүү мэдээний нөлөөгөөр Япон улсад энх тайвны төлөөх хүсэл эрмэлзэл улам бүр нэмэгдсэн юм.

Хүн төрөлхтний ертөнцөөс мөргөлдөөн, дайныг үгүй болгохын тулд улс төрийн удирдагчид төдийгүй шашин шүтлэгтнүүд биднээс "амь үрэгдэгсэд болон энх тайвны төлөөх амлалт, үйл хэрэг" явуулахыг шаардаж буй цаг үе хэзээ ч одоогийнх шиг хүчтэй байгаагүй.

Энэ жил би өдөр бүр, “Бие, хэл, сэтгэл”-ээрээ харилцах учрал болгондоо эв найрамдалтай ертөнцийг бий болгохыг найз нөхөддөө уриалж, ухамсартайгаар хүчин чармайлт гаргая гэж бодож байна






# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers

facebook

twitter



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)